



МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 1А-051

Улаанбаатар хот

Г

Г

Инкубаторын компанийг хугацаанаас  
өмнө төгсгөх тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.11 дэх заалтууд, “Мэдээллийн, технологийн инкубаторын ахисан түвшний үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6, 7 дугаар зүйлийн 7.3, 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологийн инкубаторын 39 дэх сонгон шалгаруулалтаар элсэн орсон “Майтеч” ХХК-ний бүтээгдэхүүн, үйлчилгээ нь заах зээлд нэвтрэхэд бэлэн болж хугацаанаасаа өмнө төгсөх хүсэлт гаргасан тул тухайн компанийг 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож төгсгөн гаргахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. “Майтеч” ХХК нь төгсөлтийн үнэлгээгээр 76.9% авсан тул хамтран ажиллах гэрээг дуусгавар болгох, барьцаа төлбөрийг буцаан олгохыг нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/-д, эд хөрөнгө, өрөө танхим хүлээн авахыг нярав /Ж.Уянга/, стартап менежер /Б.Энхзаяа/ нарт тус тус даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, сургалт, маркетингийн хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Э.ЦОГТГЭРЭЛ